

**СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН ЯАМНЫ
САЛБАРЫН ХЯНАЛТЫН ГАЗРААС ӨГӨХ ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ, ЗӨВЛӨМЖ**

1. Нийслэлийн Сүхбаатар дүүрэгт оршин суух Монгол Улсын иргэн “Б”-д түүний найз “У” үлэг гүрвэлийн толгойн яс буюу олдворыг 2009 онд дурсгал болгон бэлэглэжээ. “Б” уг олдворыг сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлж, хүлээлгэн өгөөгүй, гэртээ хадгалсан байна.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4-т зааснаар “Олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн сум, дүүргийн бүртгэл, мэдээллийн санд заавал бүртгүүлэх” үүрэгтэй.

Гэтэл иргэн “Б”, “У” нар нь үлэг гүрвэлийн толгойн яс буюу олдворыг сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд бүртгүүлж, хүлээлгэн өгөх талаар мэдлэггүйн улмаас зөрчил үйлдсэн болох нь шалгалтаар тогтоогдсон.

Иймд иргэн “Б”-ийн дээрх олдворыг бүртгүүлж, хүлээлгэн өгөөгүй үйлдэлд Соёлын хяналтын улсын ахлах байцаагч Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын дагуу 100.000 төгрөгөөр торгох шийтгэл оногдуулж, Тирвазовр батаар үлэг гүрвэлийн толгойн ясыг Шинжлэх ухааны академийн Палеонтологийн хүрээлэнд хүлээлгэн өгч шийдвэрлэсэн.

Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн дагуу аливаа олдвор нь төрийн өмч бөгөөд олдворыг олсон этгээд хуульд заасан хугацаанд сум, дүүргийн Засаг даргын Тамгын газарт мэдэгдэх, бүртгүүлэх, хүлээлгэж өгөх үүрэгтэй байдаг.

Энэхүү мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 17 дахь заалт, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээлэл нээлттэй, ил тод, үнэн зөв байх, бодитой мэдээллээр хангах үндсэн зарчмыг баримтлан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжийн талаар олон нийтийг мэдээллээр хангах зорилгоор хүргэж байгаа болно.



2. “О” хамтлагийн 2023 онд хийсэн нэгэн дуундаа хөгжлийн бэрхшээлтэй хүнийг олон нийтэд буруу ойлголт төрүүлэхүйц үг хэллэгтэй дуу дуулсан эсэхийг гомдлын дагуу шалган үзэхэд Q90 өвчний оноштой хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар дурдаж, олон нийтэд түгээн дуулсан нь тогтоогдож, холбогдох хууль, журмын дагуу шийдвэрлэсэн.

Тус хамтлаг нь дууны бадагт гэнэн цайлган, нуух хаах зүйл байхгүй сэтгэлээсээ ханддаг гэсэн утга санааг оруулахдаа хөгжлийн бэрхшээлтэй иргэнээр төлөөлүүлж илэрхийлсэн байгаа нь зөрчил болох шалтгаан болсон юм.

Монгол улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна” гэж заасан. Түүнчлэн Монгол улс 2009 онд Нэгдсэн Үндэстний байгууллагын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцод нэгдсэн орсноор хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, тэдний нийгмийн оролцоог дэмжих, ялгаварлан гадуурхалтыг арилгах үүргийг хүлээсэн байдаг.

Дээрх хуулийн хэрэгжилтийг хангаж тус хамтлаг нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний талаар орсон үг хэллэгтэй хэсгийг цаашид олон нийтийн арга хэмжээнд дурдаж дуулахгүй, ашиглахгүй гэдгээ албан ёсоор илэрхийлж, “В” компанийн өмч болон цацагдсан тухайн дууны бадгийг youtube сувгаас хасуулж зөрчлийг арилгуулсан.

Иймд соёл урлагийн бүтээл туурвихдаа Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.1-д “хүнийг хөгжлийн бэрхшээлээр нь доромжлох, тохуурхах, хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй гэр бүл, эцэг эхийг гадуурхах, олон нийтэд хөгжлийн бэрхшээлийн талаар буруу ойлголт төрүүлэхүйц мэдээлэл, зар сурталчилгаа явуулах, соёл урлагийн бүтээл хийх...” ялгаварлан гадуурхалт гэж үзнэ.” гэж заасны дагуу хөгжлийн

бэрхшээлтэй хүнийг хөгжлийн бэрхшээлийн талаар олон нийтэд буруу ойлголт төрүүлэхүйц үг хэллэг хэрэглэхгүй байхыг зөвлөж байна.

Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны

Салбарын хяналтын газар